



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/44

Онги

Г Хорио цээрийн дэглэм тогтоох тухай Г

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 02 дугаар хавсралтаар баталсан "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Найз багийн нутаг "Их өндөр" гэх шазар нутаглаж буй малчин Б.Шинэбаярын суурьт малын гоц халдварт бог малын мянган өвчин гарч онош нь баталгаажсан, малын эмчийн саналыг үндэслэн сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаанд хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан хүн малын хөдөлгөөнд хорио тогтоож, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, тээвэрлэхийг хориглосугай.

3. Хорио цээрийн дэглэмийг журмын дагуу явуулж, хөдөлгөөн пост ажиллуулж, хяналт тавьж нийгмийн хэв журмыг сахиулан ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (С.Болоржаргал), хэсгийн төлөөлөгч (Ш.Ууганбаяр) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж тухай бүр мэдээллээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг, багийн Засаг даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА